

# ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

## ОРШИЛ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2019 оны үйл ажиллагааны үнэлгээг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, “Бодлогын баримт бичиг, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7 дугаар хавсралтад заасан хүснэгтийн дагуу 3 багц, 10 үзүүлэлтээр дүгнэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ, яамны чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээний үзүүлэлтийн хүрээнд Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зэрэг бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилт, яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ болон 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар тусгасан зорилтын биелэлт, ил тод байдлын үнэлгээ, яамны хэрэглэгчийн үнэлгээ, Үндэсний статистикийн хорооноос гаргасан Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал 2019 оны эмхэтгэл, 2019 оны 12 сар, Хөдөө аж ахуй 2019 эмхэтгэл, Гаалийн ерөнхий газраас гаргасан Гадаад худалдааны барааны статистик 2019/12 болон гүйцэтгэлийн үр дүнг нотлох холбогдох материалууд, хэрэгжүүлэгч газруудаас тодруулга авах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн биелэлтийн 2019 онд хүрсэн бодит үр дүнг хүрвэл зохих үр дүнгийн түвшинтэй харьцуулан хувиар тодорхойлж үнэлгээг гаргав.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2019 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ 86.4 хувь буюу 4.3 оноотой байна.

## Нэг. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

1.1. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ (2019 оны жилийн эцсийн байдлаар)

Нэг. Хяналт- шинжилгээ, үнэлгээний зорилго

Монгол Улсын Хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, УИХ болон УИХ-ын Байнгын Хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан тогтоол, шийдвэр зүйл, заалтуудын биелэлтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Үнэлгээний арга зүй

Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон УИХ-ын Байнгын Хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамжийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан заалтуудын хэрэгжилтийн тайлан, холбогдох мэдээ, мэдээллийг 2019 оны жилийн эцсийн байдлаар гаргуулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв. Эрх зүйн актын биелэлтийн хувийг тогтоохдоо Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон ашигласан болно.

Эрх зүйн актын зүйл, заалтын агуулга жил бүр давтагдах шинж чанартай бол тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын үр дүнгээр, нэг удаагийн үйлчлэлтэй бол шийдвэр гарсан өдрөөс хойш хэрэгжүүлсэн үйл ажиллагааны өссөн дүнгээр тооцож гаргалаа. Мөн шийдвэр гарсны дараа ямар нэгэн үйл ажиллагаа хэрэгжүүлээгүй байхад тухайн эрх зүйн акт хүчингүй болсон бол үнэлгээ хийхгүй үлдээж ерөнхий үнэлгээ гаргах зүйл заалтын тооноос хасаж тооцсон болно.

Гурав. Үнэлгээний ажлын үр дүн

3.1. Тогтоол, шийдвэрийн хяналтад авсан заалтын тоо


Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 2019 оны жилийн эцсийн байдлаар ЗГХЭГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний албан ёсны цахим хуудсанд байршуулсан нийт 124

тогтоол, шийдвэрийн 237 заалтаас ХХААХҮЯ-ны үндсэн чиг үүрэгт хамаатай Монгол Улсын хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, Үндэсний аюулгүй байдлын хуралдааны зөвлөмж, Улсын Их Хурал, УИХ-ын Байнгын Хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар нийлсэн нийт 124 тогтоол, шийдвэрийн 237 заалтыг хяналтад авч журмын заалтуудыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

### 3.2. Үнэлгээний дундаж дүн

Хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг тайлангийн хавсралтын нэгдүгээр хүснэгтэд үзүүлэв. Нэгдүгээр хүснэгтээс харахад хяналтад авсан 237 заалтын 150 (63.3 хувь) нь бүрэн биелэгдсэн буюу 100 хувийн үнэлгээтэй, 55 (23.2 хувь) заалт хэрэгжилтийн шатанд буюу 70 хувийн үнэлгээтэй, 20 (8.4 хувь) заалт хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувийн үнэлгээтэй, 0 буюу хэрэгжээгүй заалт 3 (1.3 хувь), хугацаа болоогүй, үнэлэх боломжгүй 9 заалттай дүгнэгдсэн ба биелэлтийн дүн дунджаар 85.3 хувьтай үнэлэгдэв.

Нийт 124 тогтоол, шийдвэрийн хяналтад авсан 237 заалтын хэдэн заалт нь аль шийдвэрт хамаарч байгааг нэгдүгээр бүдүүвчээр үзүүлэв.



Нэгдүгээр бүдүүвчид үзүүлсэн тогтоол, шийдвэрийн заалтуудыг нарийвчлан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

❖ Монгол Улсын Хуулийн хяналтад авсан 6 хуулийн 16 заалт хяналтад авсны 6 заалт бүрэн хэрэгжсэн (100 хувь), 2 заалт хэрэгжих шатанд (70 хувь), 6 заалт хэрэгжилт хангалтгүй (30 хувь), 2 заалт хугацаа болоогүйгээр тус тус үнэлэгдэж, биелэлтийн дундаж 65.7 хувьтай;

❖ Улсын Их Хурлын тогтоолын хяналтад авсан 6 тогтоолын 9 заалт хяналтад авсны 3 заалт бүрэн хэрэгжиж (100хувь), 6 заалт хэрэгжих шатанд (70 хувь) үнэлэгдэж, биелэлтийн дундаж 80.0 хувьтай;

❖ Улсын Их Хурлын Байнгын Хорооны тогтоолын хяналтад авсан 1 тогтоолын 2 заалт хяналтад авсны 1 заалт хэрэгжих шатанд (100 хувь), 1 заалт хэрэгжилт хангалтгүй (30 хувь) дүгнэгдэж биелэлтийн дундаж 65.0 хувьтай;

❖ Ерөнхийлөгчийн зарлигийн хяналтад авсан 3 зарлигийн 9 заалт хяналтад авсны 3 заалт бүрэн хэрэгжсэн (100хувь), 4 заалт хэрэгжих шатанд (70 хувь), 1 заалт хэрэгжилт хангалтгүй (30 хувь), 1 заалт хугацаа болоогүйгээр тус тус үнэлэгдэж, биелэлтийн дундаж 76.3 хувьтай;

❖ Засгийн газрын тогтоолын хяналтад авсан 64 тогтоолын 104 заалт хяналтад авсны 64 заалт бүрэн хэрэгжсэн (100хувь), 32 заалт хэрэгжих шатанд (70 хувь), 3 заалт хэрэгжилт хангалтгүй (30 хувь), 2 заалт хэрэгжээгүй (0 хувь), 3 заалт хугацаа болоогүйгээр тус тус үнэлэгдэж, биелэлтийн дундаж 86.4 хувьтай;


❖ Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хяналтад авсан 34 тэмдэглэлийн 62 заалт хяналтад авсны 52 заалт бүрэн хэрэгжсэн (100 хувь), 6 заалт хэрэгжих шатанд (70 хувь), 4 заалт хэрэгжилт хангалтгүй (30 хувь) бөгөөд биелэлтийн дундаж 92.6 хувьтай;

❖ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж хяналтад авсан 5 зөвлөмжийн 14 заалт хяналтад авсны 8 заалт бүрэн хэрэгжсэн (100хувь), 3 заалт хэрэгжих шатанд (70 хувь), 2 заалт хэрэгжилт хангалтгүй (30 хувь), 1 заалт хугацаа болоогүйгээр тус тус үнэлэгдэж, биелэлтийн дундаж 82.3 хувьтай;

❖ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн хяналтад авсан 1 тэмдэглэлийн 1 заалтыг хяналтанд авсан нь “0” хувьтай үнэлэгдсэн байна;

❖ Засгийн газрын албан даалгаврын хяналтад авсан 4 даалгаврын 20 заалтыг хяналтад авснаас 13 заалт бүрэн хэрэгжсэн(100 хувь), 2 заалт хэрэгжих шатанд (70 хувь), 3 заалт хэрэгжилт хангалтгүй (30 хувь), 2 заалт хугацаа болоогүйгээр тус тус үнэлэгдэж, биелэлтийн дундаж 85.0 хувь;

Нийт тогтоол, шийдвэрийн хяналтад авсан заалтуудыг ХХААХҮЯ-ны аль газар хэлтэс толгойлон хэрэгжүүлж, хэдэн хувьтай хэрэгжилттэй зохион байгуулсныг хоёрдугаар бүдүүвчээр үзүүлэв.



### 3.3. Үнэлгээний ажлын үр дүнгийн хүснэгтүүд

Үнэлгээний ажлыг тоон хэлбэртэй дөрвөн хүснэгт, хэрэгжилтийн бичвэр хэлбэртэй нэг хүснэгтэн, нийт таван хүснэгтээр үр дүнг гаргаж дүгнэв. Тухайлбал:

3.3.1. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээний ажлын нэгдсэн тоон дүнг нэгдүгээр,

3.3.2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт холбогдох хууль тогтоомж, засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн явцад хийсэн үнэлгээний ажлын үр дүнд Монгол Улсын хуулийн 2, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн 2, Засгийн газрын тогтоолын 2, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 4, Засгийн газрын албан даалгаврын 2 заалт, нийт 10 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 11 заалтыг хяналтаас хасуулах шаардлагатай гэж 2 дугаар хүснэгтэд,

3.3.3. Хяналтад авсан тооноос хасуулахаар санал оруулж байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл заалтын агуулга, хяналтаас хасуулах шалтгаан, үнэлгээний дүн зэргийг 3 дугаар хүснэгтэд,

3.3.4. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн бичвэр тайланг хүснэгт хэлбэрээр 2019 оны жилийн эцсийн байдлаар гаргаж 4 дүгээр хүснэгтэд тус тус үзүүлэв.

### Дөрөв. Дүгнэлт

4.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт дунджаар 85.3 хувьтай буюу салбарын хэмжээнд тогтмол хэрэгжилттэй, 2019 оны эхний хагас жилийн үнэлгээний дүнгээс 3.0 хувиар өссөн дүнтэй байна.

4.2. ХХААХҮЯ-ны хяналтад авч хэрэгжүүлж буй Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2019 оны жилийн эцсийн байдлаар үнэлэхдээ Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санг ашиглан ХШҮ хийсэн нь ЗГХЭГ-ын үнэлгээний системийг салбартаа нэвтрүүлсэн, цаасан тайлангаас цахим тайланруу шилжсэн үр дүнтэй ажил болсон байна.

4.3. ХХААХҮЯ-ны хяналтад авч хэрэгжүүлж буй Хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийн холбогдох заалтуудыг “Салбарын байгууллага, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах заавар”-т тусгаж ХХААХҮ-ийн сайдын тушаалаар батлуулан, 2020 оны яам, салбарын байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг хэсэгт тусгасан нь салбарын хэмжээнд хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлд үр дүнтэй ажил болно хэмээн дүгнэж байна.

4.4. Өмнөх тайлангуудад гарсан нийтлэг дутагдал болох цаг хугацаа, хүний нөөц, ажлын ур чадвар, хөрөнгө ихээр шаардсан хууль, тогтоомж, тогтоол шийдвэрүүдийн хэрэгжилт хангалтгүй

хэвээр байна. Тухайлбал: 2012 онд батлагдсан “Хүнсний тухай”, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулиудыг дагаж гарах журам, жагсаалт, зааврууд боловсруулах, мөн Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн парк байгуулах зэрэг ажлууд сүүлийн 5-6 удаагийн тайлант хугацааны биелэлтэд ахиц гараагүй, хэрэгжилт тасарсан хэмээн үнэлэгдэж байна.

4.5. Яам, салбарын байгууллагуудын байгууллага доторх болон байгууллага хоорондын ажлын уялдаа, хамтын ажиллагаа муутайгаас болж зарим шийдвэр хангалтгүй хэрэгжих шалтгаан болж байна.

Тав. Зөвлөмж

5.1. ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А-159 дүгээр тушаалаар батлагдсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх аргачлал”-д заасан хугацаанд ХШҮ-ний мэдээллийн цахим санд гүйцэтгэлээ тайлагнан, баталгаажуулж хэвшихийг,

5.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах бүтцийн нэгжийн ахлах мэргэжилтэн болон түүнээс дээш зэрэгтэй албан хаагчийг томилон, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нь арга хэмжээ болгож тусган, биелэлтийг тооцож ажиллахыг,

5.3. ХШҮ-ний нэгдсэн дүнгээр хангалтгүй хэрэгжсэн, хэрэгжээгүй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтуудыг байгууллага, бүтцийн нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд арга хэмжээ болгон тусгаж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг,

5.4. Нэг удаагийн шинж чанартай, хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, үйл ажиллагаа нь өөр төрийн захиргааны төв байгууллагад шилжсэн болон цаашид хэрэгжих боломжгүй болсон тогтоол шийдвэрүүдийг тухай бүрт нь хяналтаас хасуулах тал дээр анхаарч, ХШҮДАГ-тай хамтарч ажиллаж хэвшихийг яамны бүх газар, хэлтсийн дарга, харьяа байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөмж болгож байна.

5.5. Тайлангаа заасан хугацаанд ХШҮ-ний нэгдсэн цахим системд тайлагнаж, баталгаажуулаагүй болон удаа дараа хангалтгүй тайлагнасан, ХШҮ-ний зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 4-5 удаагийн тайлант хугацаанд хангалтгүй хэрэгжүүлсэн яамны нэгжийн дарга, байгууллагын удирдлагад холбогдох журмын дагуу хариуцлага тооцож ажиллахыг ХШҮДАГ, ТЗУГ-т тус тус зөвлөмж болгож байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хийсэн үнэлгээ

	Бүгд	Шийдвэрийн төрлөөр									
		Монгол улсын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар	ҮАБЗ-ийн зөвлөмж	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл	
Хяналтанд авсан тогтоол шийдвэрийн тоо	124	6	6	1	3	64	34	4	5	1	
Заалтын тоо /Хагас жилээр/	237	16	9	2	9	104	62	20	14	1	
Үнэлгээ	Биелсэн 100.0%	150	6	3	1	3	64	52	13	8	0
	Хэрэгжих шатанд: 70%	55	2	6	0	4	32	6	2	3	0
	Хэрэгжилт хангалтгүй 30%	20	6	0	1	1	3	4	3	2	0
	Хэрэгжээгүй 0 %	3	0	0	0	0	2	0	0	0	1
	Хугацаа болоогүй	9	2	0	0	1	3	0	2	1	0
Үнэлгээ	85.3	65.7	80.0	65.0	76.3	86.4	92.6	85.0	82.3	0.0	

**Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналтаас хасах санал оруулж буй заалтуудын товчоо**

д/д	Эрх зүйн баримт бичиг	Шийдвэрийн тоо	Зүйл, заалтын тоо
1	Монгол Улсын хууль	2	2
2	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	1	1
3	Засгийн газрын тогтоол	2	2
4	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	4	4
5	Засгийн газрын албан даалгавар	1	2
Нийт		10	11

**Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналтаас хасах санал оруулж буй заалтуудын агуулга**

д/д	Шийдвэрийн огноо	д/д	Зүйл заалтын агуулга	Хяналтаас хасуулах шалтгаан	Үнэлгээ
<b>Монгол Улсын хууль</b>					
1	Зээлийн батлан даалтын сангийн тухай 2012-02-10	1	11.2. Сангийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас давхар батлан даахтай холбогдсон журмыг Засгийн газар батална.	Уг заалтыг 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөх болсон.	Үнэлэх боломжгүй
2	Үйлдвэрлэлийг дэмжих тухай 2015-07-09	2	6.1.1. "6 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх 6.1.1. Үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангах;"	Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр хүчингүй болгосон тул энэ заалтыг хасах саналтай байна.	Үнэлэх боломжгүй
<b>ҮАБЗ-ийн зөвлөмж</b>					
1	Мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-02-05	1	1.9. Хяналтгүйгээр худалдаалж байгаа ахуйн хэрэглээний хийг тусгай зөвшөөрөл бүхий хүнсний дэлгүүр, аж ахуйн нэгжээр дамжуулан худалдаалах болон ахуйн хэрэглээний хийг насанд хүрээгүй хүүхдэд худалдаалахыг хориглох шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх.	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар болон Нийслэлийн цагдаагийн газарт хамааралтай тул хяналтаас хасуулах саналтай байна.	Үнэлэх боломжгүй
<b>Засгийн газрын тогтоол</b>					
1	Малын гоц халдварт шүлхий өвчний нөхцөл байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2018-01-24 Дугаар 2018_29	1	3.. Малын гоц халдварт шүлхий өвчний хорио цээрийн болон хязгаарлалтын бүс тогтоосон аймаг, сумдын мал сүргийг дархлаажуулах ажлыг тодорхой график, төлөвлөгөөний дагуу тогтоосон хугацаанд тогтмол зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлэг, үржлийн газрын дарга П.Ганхуяг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү, холбогдох аймгийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Нэг удаагийн шинж чанартай, бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай байна.	100%
2	Хөдөө аж ахуйн салбарын 2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл хангах	2	4.. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын 2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл хангах чиглэлээр орон нутгийн байгууллагуудыг мэргэжил,	Нэг удаагийн шинж чанартай тул хяналтаас хасуулах саналтай байна.	100%

	зарим арга хэмжээний тухай 2018-07-04 Дугаар 2018_218		арга зүйн удирдлагаар хангах, шаардлагатай арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзоригт үүрэг болгосугай.		
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл					
1	2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр 59 дүгээр тэмдэглэл 2014-11-21 Дугаар 2014_59	1	II.2. “Биокомбинат” ТӨААТҮГ-ыг шинэчлэхэд Унгар Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл авах эсэх асуудлыг ойрын хугацаанд эцэслэн шийдвэрлүүлэхийг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын үүрэг гүйцэтгэгч Ш.Түвдэндоржид даалгав.	Нэг удаагийн шинж чанартай ба бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай байна.	100%
2	2016 оны 08 дугаар сарын 24-ний өдөр 43 дугаар тэмдэглэл 2016-08-24 Дугаар 2016_43	2	IX.3.3. Мал сүргээ эрүүлжүүлэх талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийн төсөл боловсруулан шийдвэрлэх арга хэмжээ авч, малын гоц халдварт өвчинтэй тэмцэх стратегийг шинэчлэн батлахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, бодлого, стратегийг хэрэгжүүлэх хөрөнгийг 2017 оны улсын төсөвт тусгахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт тус тус даалгав.	Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон тул хяналтаас хасуулах саналтай байна.	100%
3	2017 оны 7 дугаар сарын 18-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2017-07-18 Дугаар 2017_34	3	XIII.4.. Ихэнх аймаг, сумын нутаг гантай, гандуу байгаатай холбогдуулан дараахь арга хэмжээ авч ажиллахыг холбогдох сайд нар даалгав: 4.1. малчдын зүгээс малаа худалдахад нь дэмжлэг үзүүлэх, Хөгжлийн банк, Төрийн банкнаас хөрөнгө гаргах асуудлыг судлан шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Чойжилсүрэнд, мах экспортод гаргах зорилгоор малын гоц халдварт өвчингүй нутагт тусгай бүс нутаг тогтоон, малын өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэнд; 4.2. Аймаг дундын отрын бүс нутаг болон сум дундын отрын бүс нутгийн бэлчээрийн даацыг тогтоож, тухайн бүсүүдэд отроор өвөлжүүлэх малын тоо, бусад аймаг, сумдад малаа отроор өвөлжүүлэх сумдын хуваарь гарган, энэ талаарх гэрээ	Нэг удаагийн шинж чанартай ба бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай байна.	100%

			хэлцлийг одооноос хийж, мал өвөлжүүлэх ажлыг сайтар зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, аймгийн Засаг дарга нарт; 4.3. Нийт нутгаар хуурайшилт ихтэй байгаатай холбогдуулан малын тэжээл, өвсний нөөц Бүрдүүлж, хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор холбогдох хууль, журмын дагуу өвс хадлан, малын тэжээл, хивэг экспортод гаргахыг түр хугацаагаар хязгаарлах арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү нарт.		
4	2018 оны 2 дугаар сарын 22-ны өдөр 10 дугаар тэмдэглэл 2018-02-22 Дугаар 2018_10	4	IX.2. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх 2018 оны 2 дугаар сарын 7-9-ны өдрүүдэд Хэнтий, Сүхбаатар аймагт ажилласан талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг холбогдох сайд нарт даалгав: 1. Хэнтий аймгийн Хэрлэн сум, Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд Ариутгал, халдваргүйтгэлийн цэг байгуулан ажиллуулах, Хэнтий аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт ариутгалын автодук машин олгох хүсэлтийг судалж шийдвэрлэхийг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг нарт;	Нэг удаагийн шинж чанартай тул хяналтаас хасуулах саналтай байна.	70%
Засгийн газрын албан даалгавар					
1	Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх тухай 2019-10-16 Дугаар 2019_03	1	1.2. Цахим төлбөр тооцоонд шилжихтэй холбоотойгоор үйлчилгээний ажилтнуудыг сургаж бэлтгэх, төлбөр тооцооны системийн талаар иргэдэд сурталчилан таниулах.	ХХААХҮЯ-ны чиг үүрэгт хамааралгүй тул хяналтаас хасуулах саналтай байна.	Үнэлэх боломжгүй
		2	1.5. Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэхтэй холбогдуулан шаардлагатай бол эрхлэх асуудлын хүрээнд болон нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөж байгаа эрх зүйн актуудад зохих өөрчлөлт оруулах.	Үнэлэх боломжгүй ХХААХҮЯ-ны чиг үүрэгт хамаарахгүй тул хяналтаас хасуулах саналтай.	Үнэлэх боломжгүй

## 1.2. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ХАМААРАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА (2019 оны жилийн эцсийн байдлаар)

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан тус салбарын төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тухайн онд тавьсан зорилт, хүрэх түвшинтэй харьцуулан хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, дараагийн шатны төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үндэслэл, үнэлгээний арга зүй

Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн 2019 оны жилийн эцсийн тайланг судлах, Монгол Улсын болон барааны экспорт, импортын статистикийн мэдээлэлтэй тулгаж шалгах, холбогдох мэргэжилтнүүдтэй уулзаж ярилцах, тодруулга авах арга хэлбэрээр хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын бодит үр дүнг хүрэх түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж үнэлгээг гаргалаа. Үүнд: үр дүнгүй - 0, эрчимжүүлэх шаардлагатай -40, тодорхой үр дүнд хүрсэн - 70, үр дүнтэй - 100 хувь, холбогдох журмын 6.2.1.5 дахь заалтыг үндэслэн үнэлэх боломжгүй үнэлгээгээр тус тус үнэлэв.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах нийт 173 зорилт, арга хэмжээнээс 2019 оны жилийн эцсийн байдлаар үндсэн хэрэгжүүлэгчээр 137, бусад яам, байгууллагатай хамтран хэрэгжүүлэх 12, аймаг, орон нутагт тусгайлан хэрэгжүүлэх 24 зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв. 2019 оны жилийн эцсийн байдлаар тайлагнасан нийт 173 зорилт, арга хэмжээний 23.7 (41) хувийг 2016-2020 онд хэрэгжүүлэх бол 60.1 (104) хувийг 2017-2020 оны хооронд хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар ХХААХҮ-ийн салбарт хамаарах нийт 173 зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ дунджаар 83.06, үүнээс үндсэн хэрэгжүүлэгчээр ажилласан 137 зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ дунджаар 85.88, хамтран хэрэгжүүлэгчээр ажилласан нийт 36 зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ дунджаар 71.76 хувьтай тус тус үнэлэгдлээ. Үнэлгээний задаргааг авч үзвэл:

1. Нийт 173 зорилт, арга хэмжээ

- Үр дүнтэй буюу 100 хувьтай 91 (52.6%),
- Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувьтай 62 (35.8%),
- Эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувьтай 17 (9.8%),
- Үр дүнгүй буюу 0 хувьтай 0 (0.0%),
- Үнэлэх боломжгүй 3 (1.7%),

2. Үндсэн хэрэгжүүлэгчээр ажилласан нийт 137 зорилт, арга хэмжээ

- Үр дүнтэй буюу 100 хувьтай 82 (59.9%),
- Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувьтай 44 (32.1%),
- Эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувьтай 10 (7.3%),
- Үр дүнгүй буюу 0 хувьтай 0 (0.0%),
- Үнэлэх боломжгүй 1 (0.7%),

3. Хамтран хэрэгжүүлэгчээр ажилласан 36 зорилт, арга хэмжээ

- Үр дүнтэй буюу 100 хувьтай 9 (25.0%),



- Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувьтай 18 (50.0%),
- Эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувьтай 7 (19.4%),
- Үр дүнгүй буюу 0 хувьтай 0 (0.0%),
- Үнэлэх боломжгүй 2 (5.6%)

Засгийн газрын хөтөлбөрт тусгагдсан үндсэн 6 зорилтын хэрэгжилтийн дундаж үнэлгээ 83.06 хувьтай байна.

№	Зорилтын нэр	АХ тоо	Дундаж үнэлгээ
1	Эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого	2	85.0
2	Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах	134	86.5
3	Нийгмийн бодлого	5	70.0
4	Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого	5	82.0
5	Засаглалын бодлого	3	85.0
6	Аймаг, орон нутгийн талаар тусгайлан оруулах заалтууд	24	66.1
Дүн		173	83.06

2016-2019 оны хэрэгжилтийн үнэлгээний үр дүнгээр 78.3 хувьтай байна.

№	Он	2016	2017	2018	2019	Дундаж
1	Үнэлгээний дундаж хувь	97.4	66.3	71.3	85.88	80.2

Дөрөв. Дүгнэлт

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын 2019 оны жилийн эцсийн тайланг анх удаа Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санг ашиглан авч, үнэлсэн нь дэвшилттэй байлаа.

2. 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 173 арга хэмжээний хэрэгжилт 83.06, үндсэн хэрэгжүүлэгчээр ажилласан 137 арга хэмжээний хэрэгжилт 85.88, хамтран хэрэгжүүлэх 36 арга хэмжээний хэрэгжилт 71.76 хувьтай хэрэгжсэн бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ХХААХҮ-ийн салбарт хамаарах арга хэмжээний 2016-2019 оны хэрэгжилтийн дундаж үнэлгээ 80.2 хувьтай байна.

Тав. Санал, зөвлөмж

1. Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтээс гарсан үр дүнг бүрэн тайлагнах, уялдаа, хамтын ажиллагаа, санхүү хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн уялдааг сайжруулах, төлөвлөлтийг оновчтой хийх

2. Зорилт, арга хэмжээний суурь, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтэд тулгуурлан үйл ажиллагаа бус үр дүнг тайлагнах, 2020 оны эхний хагас жилд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг эртнээс хангах

3. Бусад байгууллага, орон нутагтай хамтарч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт, тайлагналтад онцгойлон анхаарах

### 1.3.МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ (2019 оны жилийн эцсийн байдлаар)

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын 2018 оны 37 дугаар тогтоолд тусгуулж, Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлж, малын ашиг шимийг нэмэгдүүлэх; Хөнгөн, хүнсний салбар, жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж, хүнсний эрүүл ахуйн чанарыг сайжруулах зорилтын хүрээнд нийт 28 арга хэмжээ хэрэгжүүлж байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго нь үндсэн чиглэлийн зорилт, үйл ажиллагааны гүйцэтгэлийг хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

#### Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Хяналтад авсан арга хэмжээний 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон тайлангийн хавсралтыг 4 дүгээр хүснэгтийн дагуу боловсруулав. Арга хэмжээний хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтооход дээрх журмын долоо дугаар бүлэгт заасныг баримталлаа.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын нэгтгэн ирүүлсэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тайлан”-г нягтлан үзэх, зарим арга хэмжээний хэрэгжилт хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж тодруулах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэв. Үнэлгээний тайланг ХХААХҮЯ-ны ТНБД-ын хурлаар арга хэмжээ тус бүрээр урьдчилан хэлэлцүүлж, гүйцэтгэлийн тайлагналтыг сайжруулах үүрэг даалгавар өгүүлснээр тайлагийн чанар дээшилж, үнэлгээнд өөрчлөлт оров. Төлөвлөсөн арга хэмжээ бүрээс хэрэгжүүлэх хугацааны төгсгөлд гарах дүнг урьдчилсан байдлаар тогтоож, үнэлгээ хийх үед гарсан бодит үр дүнгийн түвшинтэй харьцуулж хувиар илэрхийлэн үнэлгээг тодорхойлов.

#### Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний товчоо (арга хэмжээгээр)

Бодлого	Зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний биелэлт, хувиар					Дундаж үнэлгээ, %
			100	70	40	0	(-)	
- Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлж, бүтээгдэхүүний чанар, ашиг шимийг нэмэгдүүлнэ - Хөнгөн, хүнсний салбар, жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ	2	28	13	10	5	-	-	78.6

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах арга хэмжээний гүйцэтгэл 2019 оны жилийн эцсийн байдлаар 78.6 хувьтай үнэлэгдэв. Үүнд: 13 арга хэмжээ “үр дүнтэй”, 10 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 5 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн бол “үр дүнгүй” эсвэл үнэлэх боломжгүй арга хэмжээ байхгүй.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний товчоо (салбараар)

		Газар, хэлтэс								
		НБТГ	МААХБЗГ	ГТХБЗГ	ХөҮХБЗГ	ЖДҮҮХХБЗГ	ХҮҮХБЗГ	МГНХ	ХУХУСХ	МЭЕГ
Үүнээс	Бүгд	1	5	9	3	2	2	2	2	2
	100 %	-	3	2	-	2	2	-	2	2
	70%	1	1	4	1	-	-	2	-	-
	40%	-	1	3	2	-	-	-	-	-
	0%	-	-	-	-	-	-	-	-	-
	Үнэлэх бол-гүй	-	-	-	-	-	-	-	-	-
Үнэлгээ		70.0	82.0	66.7	50.0	100.0	100.0	70.0	100.0	100.0

Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг салбар бүрээр авч үзвэл Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар 1 арга хэмжээг 70.0, Мал аж ахуйн хөгжлийн бодлого, зохицуулалтын газар 5 арга хэмжээг 82.0, Газар тариалангийн хөгжлийн бодлого, зохицуулалтын газар 9 арга хэмжээг 66.7, Хөнгөн үйлдвэрийн хөгжлийн бодлого, зохицуулалтын газар 3 арга хэмжээг 50.0, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны бодлого, зохицуулалтын газар 2 арга хэмжээг 100.0, Хүнсний үйлдвэрийн хөгжлийн бодлого, зохицуулалтын 2 арга хэмжээг 100.0, Малын генетик, нөөцийн хэлтэс 2 арга хэмжээг 70.0, Хөрс, ургамал хамгаалал, үр сортын хэлтэс 2 арга хэмжээг 100.0, Мал эмнэлэгийн ерөнхий газар 2 арга хэмжээг 100.0 хувийн гүйцэтгэлтэйгээр тус тус хэрэгжүүлсэн байна.

#### Дөрөв. Дүгнэлт

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах зорилт, арга хэмжээний жилийн эцсийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 78.6 хувьтай үнэлэгдэв

2. Доор дурдсан зорилт арга хэмжээний хэрэгжилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай буюу “40” үнэлгээтэй байв. Үүнд:

4.2. Өвөл, зуны хүлэмжийн нэмэгдэх талбай, га (ГТХБЗГ)

4.3. Улаанбаатар хотод төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн хадгалалт, борлуулалтын цогцолбор төв байгуулах, барилгын ажлын явц, хувиар (ГТХБЗГ)

4.4.4. Үр тарианы талбайн хөрсний үржил шимийг сайжруулах, ургацын хэмжээг нэмэгдүүлэх, алслагдсан бүс нутгийн тариалалтыг дэмжих, алслагдсан бүс нутагт шинээр элеватор байгуулах ажлын явц, хувиар (ГТХБЗГ)

4.5. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлж, үйлдвэржүүлэх бодлого хэрэгжүүлэх (ХөҮХБЗГ)

4.8. Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн парк байгуулах, ажлын явц, хувиар (ХөҮХБЗГ)

3. Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоол, “Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах тухай” журмын дагуу жагсаалтын ангиллын хүрээнд мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг тайлагнахгүй байгаагаас санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалтын ангилал тодорхой бус байна.

4. Мал, амьтны өвчний гаралт, вакцинжуулалтын арга хэмжээний гүйцэтгэл зэрэг мэдээллийг цаг тухай бүрт шууд авах боломжтой /цахим технологийн шийдэл, мэдээллийн сангийн програм ашиглах гэх мэтээр/болгох шаардлагатай. Мэдээ, мэдээллийг бүтэн улирлаар хоцорч авч байгаа нь үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэхэд учир дутагдалтайгаас гадна босоо удирдлага, тогтолцоотой байгууллагын хувьд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах зэрэг арга хэмжээ бодитой хэрэгжиж байгаа гэж үнэлэхэд учир дутагдалтай байна.

#### Тав. Зөвлөмж

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусгах ХХААХҮ-ийн салбарын зорилт, арга хэмжээний төсөл боловсруулахдаа дээр дурдсан нөхцөл байдал, эрсдэлийг тооцож тусгах, шалгуур үзүүлэлтийг Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам баримтлан нарийвчлан тогтоох, өмнөх жилүүдэд хэрэгжилт хангалтгүй, яамны үнэлгээнд сөрөг нөлөөлсөн зорилт, арга хэмжээг тусгахгүй байхыг Санхүү, хөрөнгө оруулалтын газарт;

2. Вакцинжуулалтын мэдээг Засгийн газрын 2018 оны “Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах тухай” 225 дугаар тогтоолд заасан ангиллын дагуу боловсруулж тайлагнаж байхыг Мал эмнэлгийн ерөнхий газарт;

3. Мал эмнэлгийн үйлчилгээний мэдээллийг цаг тухайд нь шуурхай авч байх мэдээллийн сангийн тогтолцоо бүрдүүлэхийг Мал эмнэлгийн ерөнхий газарт ;

4. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, “Бодлогын баримт бичиг, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А-159 дүгээр тушаал, “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын баримт бичиг, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу тайлагнаж байхыг бүх газар, хэлтэст тус тус зөвлөж байна.

1.4 ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭДИЙН ЗАСАГ,  
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ (2019 оны жилийн эцсийн байдлаар)

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Яамдын эдийн засаг, нийгмийн хөгжлийг үзүүлэлт батлах тухай” 55 дугаар тогтоолын хавсралтад заасан зорилтот түвшинг салбарын статистик, мэдээлэл, судалгаа хариуцсан ахлах мэргэжилтний ирүүлсэн хүрсэн түвшинг харьцуулж үнэлэв.

№	Үзүүлэлт	Суурь үзүүлэлт 2016	Зорилтот түвшин, 2019	Хүрсэн түвшин, 2019	Үнэлгээ
1	Хөдөө аж ахуйн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүний эзлэх хувь	12.0	14.0	11.0	78.6
2	Аж үйлдвэрийн салбарын бүтцэд хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлийн эзлэх хувь	10.6	11.8	9.3	78.8
3	Аж үйлдвэрийн салбарын бүтцэд хөнгөн үйлдвэрийн эзлэх хувь	7.2	7.8	7.9	100
4	ДНБ-ийн үйлдвэрлэлд худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээний салбарын эзлэх хувь	17.3	17.6	17.7	100
5	Нийт экспортод боловсруулах үйлдвэрийн эзлэх хувь	14.0	14.7	14.8	100
6	Монгол Улсын нийт төсөвт хүнс, хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь	2.0	2.8	2.1	75.0
7	Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах, мянган тонн	16.8	75.0	31.7	42.3
8	Нийт сүү үйлдвэрлэлд эзлэх үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний эзлэх хувь	9.0	25.0	17.0	68.0
9	Нийт сүрэгт эзлэх үхрийн хувь	6.7	7.6	6.7	88.2
10	Тариалангийн эргэлтийн талбай, мянган га	885.0	1000.0	870.0	87.0
11	Хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээс хангах түвшин, хувь	54.0	80.0	40.0	50.0
12	ХАА-н салбарт ажиллагсдын тооны өөрчлөлт (мянга, IV улирал)	352	392.0	310.0	79.1
13	Хоршооны тоо (мянга)	4.3	4.9	4.6	93.9
14	Хүнсний салбарт ажиллагсдын тооны өөрчлөлт (мянга, IV улирал)	13.5	14.5	14.1	97.2
15	Хөнгөн үйлдвэрийн салбарт ажиллагсдын тооны өөрчлөлт (мянга, IV улирал)	50.9	54.6	54.7	100
	Дундаж үнэлгээ				82.7

## Хоёр. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

2.1.БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТ

Тус яамнаас 2019 онд стратегийн 8 зорилтын хүрээнд 282 үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлсэн ба төлөвлөгөөний биелэлт, үр дүнгийн хүрсэн түвшинд үндэслэн хийсэн үнэлгээгээр гүйцэтгэл 89.4 хувьтай дүгнэгдэв.

## 2.1.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны алсын хараа

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, жижиг дунд үйлдвэр, хоршоо, дотоод худалдаа, үйлчилгээний салбарыг олон улсын зах зээлд өрсөлдөхүйц хөгжлийн шинэ шатанд гаргаж эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.

## 2.1.2. Эрхэм зорилго

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь салбарын бодлогыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэх замаар түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, импортыг орлох, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн орлого, бүтээмжийг өсгөн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн салбарын эдийн засгийн өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл, аюулгүй, шим тэжээллэг хүнс, эрүүл ахуй, хэрэглээний шаардлага хангасан хувцас, хэрэгслээр хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

2.1.3. Байгууллагын 2018 онд үйл ажиллагааны төлөвлөгөөний бүтцэд хийсэн шинжилгээ (үйл ажиллагаа, газраар)

№	Газрын нэр	Үйл ажиллагаа		Нийт тоо	Эзлэх хувь, %
		Нийтлэг	Тусгай		
1	НБТГ	22	40	62	22.0
2	ТЗУГ	21	13	34	12.1
3	МААХБЗГ	30	20	50	17.7
4	ГТХБЗГ	16	21	37	13.1
5	ХөҮХБЗГ	13	8	21	7.4
6	ХүҮХБЗГ	13	7	20	7.1
7	ЖДҮҮХХБХЗГ	12	8	20	7.1
8	ХШҮДАГ	15	23	38	13.5
	Дүн	142	140	282	100.0

ХХААХҮЯ-ны 2018 оны төлөвлөгөөний 62 ажил буюу 22.0 хувийг НБТГ тусгаж хэрэгжүүлсэн бол ХШҮДАГ, ГТХБЗГ, ТЗУГ, МААХБЗГ тус тус 50-34 ажил буюу 17.7-12.1 хувийг гүйцэтгэсэн. ХүҮХБЗГ, ХөҮХБЗГ ба ЖДҮХБХЗГ 7.2 хувийг тус тус тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллав.

2.1.4. Байгууллагын төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн (газраар)

Газар	Нийтлэг үйл ажиллагаа		Тусгай үйл ажиллагаа		Нийт ажил	Дундаж үнэлгээ
	Тоо	Хэсгийн үнэлгээ	Тоо	Хэсгийн үнэлгээ		
НБТГ	22	95.25	40	89.5	62	92.4
ТЗУГ	21	96.25	13	95.0	34	95.6
МААХБЗГ	30	83.35	20	78.0	50	80.7
ГТХБЗГ	16	91.8	21	89.0	37	90.4
ХөҮХБЗГ	13	74.6	8	85.0	21	79.8
ХүҮХБЗГ	13	80.0	7	92.85	20	86.4
ЖДҮҮХХБХЗГ	12	90.0	8	92.5	20	91.3
ХШҮДАГ	15	98.0	23	93.5	38	95.8
	142		140		282	89.4

ХХААХҮЯ-ны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд өгсөн ХШҮ-ний дүнгээр ХШҮДАГ, ТЗУГ, НБТГ, ЖДҮҮХХБТГ болон ГТХБЗГ “үр дүнтэй” буюу 90.0-ээс дээш, бусад газар “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 79.8 - 86.4 хувьтай үнэлэгдсэн бол яамны дундаж үнэлгээ 89.4 хувьтай байв.

Тус яамны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 282 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгагдснаас 30-аас доош үнэлгээтэй 26 арга хэмжээний хэрэгжилтэд сөрөг нөлөөлсөн хүчин зүйлийг судалж үзсэн. Төлөвлөгөөний хэрэгжилт 50 хувь хүний нөөц, 8 хувь удирдлага зохион байгуулалт, 31 хувь тооцоолоогүй гадны эрдслээс, 11 хувь санхүүжилтээс хамааран хэрэгжээгүй эсвэл хэрэгжилт хангалтгүй байв.

Нөлөөлөх хүчин зүйл	Арга хэмжээний	
	тоо	хувь
1. Хүний нөөцийн хүчин зүйл (төлөвлөлт, ажлын ачаалал, ажлын уялдаа)	13	50
2. Удирдлага, зохион байгуулалт, байгууллага, газар хоорондын уялдаа	2	8
3. Гадаад эрдэлт хүчин зүйл	8	31
4. Санхүүжилт	3	11

2.2. БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛУУЛАХ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

1. “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны албан хаагчдад зориулан 2019 онд зохион байгуулах сургалт, мэдээллийн цаг”-төлөвлөгөөнд 10 арга хэмжээ тусгаж, 9 арга хэмжээ 100, 1 арга хэмжээ 40 хувьтай үнэлэгдэж, дунджаар 94 хувийн гүйцэтгэлтэй байв.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах” хөтөлбөрт нийт 26 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөсөн. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай үнэлэгдсэн. Уг төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний 70 хувь нь холбогдох хууль, журам, дотоод журмаар зохицуулагддаг, хэрэгжилт нь бүрэн хангагддаг ажил байгаа нь дээрх зорилтын хүрээний ажил боловч нөгөө талаас авч үзвэл ямар ч тохиолдолд хэрэгждэг найдвэртэй төлөвлөлт болсон байх тул яамны албан хаагчдаас санал асуулга авч, тэдний саналыг тусгасан, бүтээлч арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

### Гурав. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

#### 3.1. Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тайлагнах үнэлгээ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичиг, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 11 дүгээр хүснэгтэд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг үндэслэн хийлээ. Яамны 2019 оны үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ 93.7 хувьтай дүгнэгдэв.

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	- Яамны өдөр дутмын үй ажиллгатай холбоотой 404 шинэ мэдээ, худалдан авах бараа үйлчилгээний 177 урилга, ЗГ-ын 5 тогтоол, Сайд, ТНБД-ын 19 тушаал, хяналт-шинжилгээ, үнэлгээний 17 тайлан, 6 зарлал, 8 тайлан төлөвлөгөө, Улаанбаатар хотын гол нэрийн зарим барааны үнийн 48 мэдээ, хөдөө аж ахуйн биржийн 48 мэдээ, шинээр боловсруулсан эрх зүйн бичиг баримтын төслийн 37 удаагийн хэлэлцүүлэг ХХААХҮЯ-ны цахим хуудсанд байршуулсан. Мөн эдгээр мэдээлэл нь яамны дотоод мэдээллийн Е-оффис программд давхар орсон. - Вэб хуудсыг шинэчлэн баяжуулахад шаардлагатай мэдээллийг мэдээлэл хариуцсан мэргэжилтнүүдээс авч салбарын мэдээллийг 2019 онд хийсэн ажил, статистик тоон үзүүлэлт болон 2020 онд хийх ажлын чиглэлээр зарим мэдээллийг шинэчилсэн. Төрийн байгууллагын стандартад нийцсэн байна.	100
2	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Яамны <a href="http://mofa.gov.mn/exp/static/contact_us">http://mofa.gov.mn/exp/static/contact_us</a> вэб хуудсын холбоо барих хэсэгт яамны газар, хэлтсийн мэргэжилтнүүдийн утасны дугаарын мэдээллийг оруулсан. Мөн холбоо барих И-мэйл: <a href="mailto:mofa@mofa.gov.mn">mofa@mofa.gov.mn</a> , Вэб: <a href="http://mofa.gov.mn">mofa.gov.mn</a> , Утас: 51-262271, Факс: 51-263237, Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 13381, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IХа байр	70
3	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Яамны <a href="http://mofa.gov.mn/exp/blog/43/93">http://mofa.gov.mn/exp/blog/43/93</a> вэб хуудсанд тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон тусгай зөвшөөрөл авсан аж ахуй нэгжийн мэдээллийг тогтмол оруулж байна.	100
4	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж, дүрэм журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Яамны <a href="http://mofa.gov.mn">http://mofa.gov.mn</a> вэб хуудсын нүүр хэсэгт хууль, эрх зүй үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж, дүрэм журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэж байна.	100
5	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим	Яамны <a href="http://mofa.gov.mn">http://mofa.gov.mn</a> вэб хуудсын нүүрний доод хэсэгт шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн 37 төслийг цахим хуудсандаа 30-аас	100

	хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах	доошгүй хоног байрлуулж саналыг хүлээн авч байна.	
6	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Яамны цахим хуудсанд тусгай зөвшөөрөл</li> <li>- салбарын шагнал авахад бүрдүүлэх баримт бичиг, түүний хураамж</li> <li>- иргэдээс цахим хэлбэрээр өргөдөл, гомдол авах, өргөдөл гомдол, санал, хүсэлт хариуцсан мэргэжилтний хаяг, зөвлөмж, өргөдөл, гомдол, санал хүсэлтийн улирал бүрийн мэдээг байрлуулан иргэдийн санал гомдлыг цахим хэлбэрээр авч байна.</li> <li>- тусгай зөвшөөрлийн гэрчилгээ авсан, сунгасан байгууллагын гэрчилгээний үнэ төлсөн жагсаалт</li> <li>- шилэн данс</li> <li>- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчээр бүртгүүлэхэд шаардагдах материал зэрэг мэдээллийг ил тод нээлттэй байршуулав.</li> <li>- Ноос, арьс шир, улаан буудайн урамшуулалттай холбоотой мэдээлэл авахад зориулж линкээр холбов</li> </ul>	70
7	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухай төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх	Тус яам 2019 онд 19 төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, нийт 1,645.74 сая төгрөгийн ажил, зөвлөх үйлчилгээ гүйцэтгүүлсэн. Эдгээрээс “Монголын ноос, ноолуурын холбоо” ТББ ноосны чанар тогтоож, үнэлгээ хийх ажжлыг гүйцэтгэж байгаа бөгөөд холбогдох мэдээллийг яамны цахим хуудаст нөхөж байршуулсан болно.	100
8	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Яамны <a href="http://mofa.gov.mn/exp/blog/43/93">http://mofa.gov.mn/exp/blog/43/93</a> вэб хуудсанд тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон тусгай зөвшөөрөл авсан аж ахуй нэгжийн мэдээллийг оруулсан.	100
9	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр 7 хөтөлбөр, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа 7 төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх хяналт-шинжилгээ үнэлгээний тайлангийн жилийн эцсийн байдлаар цахим хуудсандаа мэдээллийг байрлуулж байна.	100
Хэсгийн дундаж хувь:			93.3
Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал			
1	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах	Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн даргын ажлын байрны сул орон тоо, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Худалдаа, нийтийн хоол, үйлчилгээний зохицуулалтын хэлтсийн даргын ажлын байрны сул орон тоог тус тус нийтэд нээлттэй зарлаж, Төрийн албаны зөвлөлийн болон яамны цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулав. Хөнгөн үйлдвэрийн бодлогын	100

		хэрэгжилтийг зохицуулах газрын Сав, баглаа боодол, дахин боловсруулах болон барилгын материал үйлдвэрлэлийн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоог төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй иргэдээс нөхөх зарыг Төрийн албаны зөвлөлийн болон яамны цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулав.	
2	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Яамны цахим хуудас www.mofa.gov.mn-ны “Хүний нөөц” буланд Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн тухай зөвлөмж, хичээл, сургалтын материалыг байрлуулснаар ёс зүйн тухай ойлголт, мэдээлэл авах боломж нөхцлөөр хангалаа. Мөн Ёс зүйн хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тоймыг байршуулав. Яамны цахим хуудасны “Хүний нөөц” буланд иргэдээс “Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагын талаар санал, хүсэлт хүлээн авах” буланг ажиллуулж, байгууллагын 1 давхарт байрлах Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах мэдээллийн самбарын дэргэд иргэдийн санал, хүсэлтийг хүлээж авах “Саналын хайрцаг” ажиллуулж байна.	100
3	Хүний нөөцийн стратеги, түүнийг хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 126 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэх журам"-д заасны дагуу хүний нөөцийн стратеги, үйл ажиллагааг үнэлүүлж байна.	100
4	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх	- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалын сул орон тоог нөхөх захиалгыг Төрийн албаны зөвлөлд Салбар зөвлөлийн 2019.09.25-ны өдрийн 02 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Шалгалтын мөрөөр дүгнэлтээр гарсан Төрийн албаны зөвлөлийн тогтоолын дагуу ТНБД-ын Б-127 дугаар тушаалаар ахлах мэргэжилтэн Ч.Тавинжилийг ХШҮДАГ-ын даргаар томилсон байна. - Газар тариалангийн хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын Хөрс, ургамал хамгаалал, үр сортын хэлтсийн даргын албан тушаалын сул орон тоог “Тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын дагуу олон нийтэд нээлттэй зарлаж, комисс томилон бүртгэлийг 2 өдөр явуулж, шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтын дүнгээр ГТХБЗГ-т ахлах мэргэжилтнээр ажиллаж байсан Д.Есөн-Эрдэнийг ТНБД-ын 2019 оны Б-128 дугаар тушаалаар уг албан тушаалд томилсон.	100
5	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх	Салбар зөвлөлийн 1 дүгээр хуралдаанаар гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1, 2 дугаар улирлын тайлангийн дүнг хэлэлцэж баталгаажуулан “Хангалттай” үнэлгээ авсан албан хаагчдад ТНБД-ын А-294 дүгээр тушаалаар нийт 58,4 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон. 5 дугаар хуралдаанаар 3-4 дүгээр улирлын гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээг хэлэлцэж, ТНБД-ын А-542 дугаар тушаалаар нийт 108 албан хаагчид 66,7 сая төгрөгийн урамшуулал олгов.	70
Хэсгийн дундаж хувь:			94.0
Хэрэгжилтийн дундаж хувь:			93.7



## 3.2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичиг, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.10-д заасны дагуу Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх болно.

Шилэн дансны цахим системд 2019 оны 4-р улирлын байдлаар ХХААХҮ-ийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх хүрээний нийт 67 байгууллага (ХХААХҮ-ийн ТЕЗ, ХХААХҮЯ, харьяа 12 байгууллага, Хүнс, хөдөө аж ахуйн 21 газар, Мал эмнэлэгийн 21 газар, 6 төсөл, Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 5 салбар)-ын нийт 3765 мэдээлэл байршуулахаас хугацаанд нь 3498, хугацаа хоцорсон 267 мэдээллийг нөхөж байршуулсан болно.

Үзүүлэлт	Мэдээллийн тоо			Гүйлгээ, шийдвэрийн тоо
	Байршуулах ёстой	Хугацаандаа байршуулсан	Хоцроосон, нөхөж байршуулсан	
Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газар	1541	973	224	-
тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, байгууллагын төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт, тендер худалдан авалттай холбоотой	201	167	11	-
Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэлд 267,355.06 сая төгрөгийн	-	-	-	3394 (гүйлгээ)
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний мэдээлэлд 367,853.9 сая төгрөг	-	-	-	3517 (гүйлгээ)
Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний мэдээлэлд 238,277.35 сая төгрөг	-	-	-	2749 (гүйлгээ)
Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилгах санхүүгийн бусад хэрэгслийн талаарх шийдвэрийн мэдээлэлд 81,169.22 сая төгрөгийн	-	-	-	640 (гүйлгээ)
Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэлд 157,368.87 сая төгрөгийн	-	-	-	434 (шийдвэр)
Авлага үүсгэсэн шийдвэрийн талаарх мэдээлэлд 47,430.12 сая төгрөгийн	-	-	-	91 (шийдвэр)

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж байгууллагын мэдээлэлд 300 аж ахуй нэгжтэй 50 165.3 сая төгрөгийн гэрээ байгуулж ажил гүйцэтгүүлсэн байна. I улиралд 59, II улиралд 51, III улиралд 56, IV улиралд 134 мэдээлэл байршуулсан байна.

2. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчийн мэдээлэлд нийт 1917 аж ахуй нэгж, иргэнд /давхардсан тоогоор/ 644,973.75 сая төгрөгийн гэрээ байгуулж, санхүүжилт хийгдсэн байна. I улиралд хугацаандаа 954, хугацаа хоцроож 463, нөхөж 500 иргэн, аж ахуйн мэдээллийг нөхөж байршуулсан.

## 3.3. Шударга байдлын түвшний үнэлгээ

АТГ-аас байгууллагын авилгын эсрэг явуулж буй үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ тус яамны Авилгын эсрэг үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг Авилгатай тэмцэх газарт хүргүүлсэн бөгөөд манай байгууллагын авилгын эсрэг явуулж буй үйл ажиллагаанд өгсөн үнэлгээг холбогдох байгууллагаас түүгээр хүргүүлэх тул яамны үйл ажиллагааны үнэлгээний дүнд оруулалгүй хасаж тооцсон болно.

## 3.4. Хэрэглэгчийн үнэлгээ

ХХААХҮЯ-ны 2019 оны “Хэрэглэгчийн үнэлгээ хийх” зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулах Үнэлгээний хороог ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А-05 дугаар тушаалаар байгуулан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу зохион байгуулав.

Хэрэглэгчийн үнэлгээний судалгааны ажлыг гүйцэтгүүлэхээр 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр “Эрдмийн мэлмий” нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагатай 200316/10/077 дугаартай гэрээ байгуулсан. Хэрэглэгчийн үнэлгээг төрийн бодлогын хэрэгжилт, төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэд, аж ахуйн нэгжүүдийг хамруулан явуулсан.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын хэрэгжилтийн талаарх хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ Төв, Орхон аймаг болон нийслэлийн Багахангай дүүргийн насанд хүрсэн 1216 хэрэглэгчдийг хамруулсан.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хэрэглэгчийн үнэлгээний энэ удаагийн судалгаанд хамрагдсан нийт хэрэглэгчийн үнэлгээг нэгтгэж салбарын ерөнхий үнэлгээ 81.8 хувьтай гарч байна. Хэрэглэгчийн үнэлгээний тайланг хавсралтаар хүргүүлсэн болно.

### Дөрөв. ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	85.3	0.6	49.5
	2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	83.06		
	3.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт	78.6		
	4.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	82.7		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	89.4	0.2	18.6
	2.Байгууллагын хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажилуулах талаарх тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан зорилтын биелэлт	97.0		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	93.7	0.2	18.3
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	99.3		
	3. Шударга байдлын түвшний үнэлгээ	-		
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	81.8		
Ерөнхий үнэлгээ			1	86.4

### Тав. ДҮГНЭЛТ

5.1 Хүнс, хөдөө аж ахуйн яамны 2019 оны үйл ажиллагааны үнэлгээний дүн Бодлогын зорилтын хэрэгжилт, Байгууллагын чиг үүргийн үзүүлэлт, байгууллагын нээлттэй байдал, Үйл ажиллагааны үр дүнг багцалсан үзүүлэлтээр 86.4 хувийн үнэлгээтэй буюу 4.33 гэсэн оноотой байна.

5.2 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 85.5, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Хүнс, хөдөө аж ахуйн салбарын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг 2018 оны жилийн эцсийн байдлаар үнэлж үзэхэд хэрэгжилт дунджаар 83.06, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт 78.9 хувьтай үнэлэгдсэн нь жинлэсэн дундаж үнэлгээ 60-аас 49.5 байв.

5.3 “Хэрэглэгчийн үнэлгээ” зөвлөх үйлчилгээ гүйцэтгэсэн “Эрдмийн мэлмий” нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын судалгааны үр дүнгээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хэрэглэгчийн ерөнхий үнэлгээ 81.8 хувьтай байгаа нь салбарын хэрэглэгчдийн сэтгэл ханамж өндөр байгааг илтгэж байна.

### Зургаа. ЗӨВЛӨМЖ

6.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2019 оны үйл ажиллагааны үнэлгээний тайланд тусгасан бодлогын баримт бичиг бүрээс өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг;

6.2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А-159 дүгээр тушаалаар баталсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-д заасныг баримтлан тогтоосон цаг хугацаанд, зохих шаардлагад нийцүүлэн, тайлагийн чанарыг дээшлүүлэн тайлагнаж байхыг бүх газар, хэлтэст тус тус зөвлөж байна.